

## УЛСЫН ХИЛИЙН БАТАЛГААЖИЛТ ХАМГААЛАЛТЫН ТАЛААР ӨВӨГ, ДЭЭДСИЙН ХАЙРЛАСАН ҮНДЭСНИЙ УЛАМЖЛАЛТ СУРГАМЖ

**Ш.Арвай\***

Монгол судлал дэлхийн түүхэнд зохих байраа баттай эзэлсэн нь бахархууштай. Энэ арвин түүхтэй улсын хил хязгаарыг гүнзгий судлах шаардлагатай. Энд Монголд төдийгүй дэлхийд хосгүй нандин туршлага их бий. Монгол Улсад хил судлал шинжлэх ухааны салбарын хэмжээнд албан ёсоор авч үзээд цөөхөн жилийн нүүр үзэж байна.

Улсын хил хязгаар нь улсын тусгаар тогтнол, бүрэн эрх, газар нутгийн бүрэн бүтэн байдалтай амин сүнсний холбоотой байдаг билээ. Ийм ч учраас Монгол судлалын чиглэлээр гадаад дотоодын эрдэмтэн судлаачдын бүтээлд хил хязгаар ямар нэгэн хэмжээгээр тусгагдаж хөндөгдөж ирсэн нь ойлгомжтой.

Хоёр мянга хоёр зуун жилийн тэртээ “өмнө зүгт Цагаан хэрэм, умар зүгт Байгал нуур, баруун зүгт Ил тарвагатай, дорно зүгт Солонгос хүртэл уудам их нутаг эзлэн байсан гүрэн тал талаасаа шимэгдсээр одоо Монгол Улс 8162,8 км урт хилтэй 1 сая 500 мянган хавтгай дөрвөлжин газар нутаг бүхий дэлхийн тодорхой нэгэн орон зайг эзэгнэн оршиж байна. Энэ орон зай амар хялбар олдоогүй юм.

Энэ бол төрт ёсоо өргөмжлөн дээдэлж, хувь тавилангаар олгогдсон уугуул газар нутагтаа эзэн нь байж, түүний үр шимийг хүртэж хүний жамаар амьдрахыг эрмэлзсэн Монгол түмний хоёр эрин хорин хоёр зууны турш явуулсан шударга тэмцлийн бодит үр дүн юм.

Миний хувьд Монгол Улсыг олон улсын хэмжээнд хүдээн зөвшөөрсөн тэр хэмжээнд ард түмний баталсан үндсэн хуульт Монгол Улсын хөгжил дэвшлийг хангахад улсын батлан хамгаалалт, ялангуяа улсын хил, түүнийг манах хамгаалахад зайлшгүй анхаарч авах ёстой өвөг дээдсийн туулсан түүхээс зүй тогтлын шинжтэй сургамжийг судалгаанд түшиглэн олох гол зорилго дэвшүүлсэн юм. Энэ байдлыг тойм төдий дурдвал:

Нэгдүгээрт: Аливаа улсын тусгаар тогтнол, бүрэн эрх,

\*Ш.Арвай. Цэргийн шинжлэх ухааны доктор (Ph), профессор, дэслэгч генерал

газар нутгийн бүрэн бүтэн байдлын мөн чанар нь дэлхий ертөнцөд тухайн улсын эзлэх “орон зай” юм байна гэсэн ойлголт төрж байна. Монгол Улс 2200 гаруй жил тодорхой орон зайнд оршин иржээ. Дэлхийд ямар ч улсыг ихэвчлэн эзэмших газар нутгаар төсөөлөх хандлага байдаг. Гэтэл түүхээс харахад энэ нь зөвхөн газар нутаг биш, түүний хөрсөнд байгаа баялаг, агаар мандал, энэ нутагт байгаа төрийн тогтолцоо, нийгмийн байдлыг бүх талаас нь хамардаг учраас ерөнхийд нь тодорхой оршин байгаа нийгэм-газар зүйн орон зайгаар авч үзэх шаардлага гарч байна. Үүнд дараах үндэслэлийг харгалзан үзэв.

- Монголчууд амьжиргааны эрх ашигт хөтлөгдөн ой, ус, нөмөр нөөлөг, ан амьтан жигдэрсэн өрнийн Алтайн нуруу, умарын Саян болон Яблоновын нуруу, дорнын их Хянганы нуруу, өмнийн Иньшаний нуруугаар хүрээлэгдсэн Уссур мөрнөөс Дунай мөрөн хүртэл сунаж тогтсон их тал хээрийн зүүн хэсэгт оршин байлаа. Тэр үед Монголчууд аль болохоор их газар нутаг эзэмшихын төлөө байв уу аль эсвэл амьжиргааны эрх ашигт илүү хөтлөгдөж байв уу гэдэг асуудал анхаарал татдаг. Монгол судлаач Л.Н.Гумилев МЭӨ III-II зууны Хүннү-Хятадын дайныг шинжлэн үзээд “Хоёр тал бие биений газар нутгийг эзлэн авах сонирхол тавиагүй юм. Яагаад гэвэл газрыг нь боловсруулан ашиглах бололцоогүй учир Хүннүгийн нутаг дэвсгэр Хятадад хэрэггүй байв. Хятадын тариа ногоо тарьж боловсрогдсон хөндийнүүдэд мал хариулах бололцоогүй учир Хятадын газар нутаг Хүннүд ашиггүй байлаа...” [Гумилев.Л.Н. Древний мир. Сборник статей в честь академика В.В.Струева. М., 1962] гэжээ.

Эндээс үүдэн хилчдэд төрийн тогтолцооноос гадна нийгэм, иргэдийн эрх ашгийг хамгаалах шаардлагатай гэсэн сургамж гарч байна.

- Монгол Улсын агаар цэлмэг, цэвэр, нарлаг учраас ялангуяа шинэ зуунд сансар агаарын хэрэгслийг түлхүү ашиглах магадлал харагдаж байгаа үед Монгол улсын нутагт улсын болон орон нутгийн мөн олон улсын агаарын тээврийг хөгжүүлэхэд нэн тохиромжтой. Энэ бол агаарын орон зайн онцлог юм. Үүний зэрэгцээ Атлантын далай, Номхон далайн агаарын урсгал Монголын нутагт мөргөлдөх, түлхэлцэх нөхцөл байдлын улмаас уул хөвчид хур тунадас ихдэн, зуд турхан болсоноос говь тал руу нүүдэллэх, мөн энэ хэсэгт ган, гачлан тохиолдсоноос хангай хөвчийг бараадан шилжих зүй тогтол, үзэгдлээс болж Монголчууд суурин амьдралаас

нүүдлийн уламжлалт хэв шинжийг голлон хадгалж иржээ. Энэ нь цөөн хүн амтай боловч мал аж ахуй голлон эрхэлдэг Монголчуудад өргөн уудам нутагт тархан аж төрж нийгмийн хэрэгцээг өөрсдөө дор бүрнээ бие даасан байдлаар хангах зарчим баримтлахад хүргэж байжээ.

Хилчдийн хувьд энэ чиглэлээр нэн анхааралтай хандаж сурах юм их байна.

Хоёрдугаарт: Аливаа улсын нутаг дэвсгэр, тэр хэмжээнд оршин байдаг төрийн тогтолцоо, нийгмийн байгуулал багтаасан орон зай нь тодорхой хүрээ хязгаарт багтан оршдог хуультай юм байна. Хязгаараар зааглаагүй орон зай гэж хэзээ ч хаана ч байгаагүй, байх ч ёсгүй. Ямар ч улс нэг бол эзэмшлийн хязгаарыг өргөжүүлэх, эсвэл түүнийг бусдад алдаж хумиж багасгахгүй байлгах мөн зааглан тогтоосон хэмжээнд хязгаарыг адил тэгш эрхтэй тогтвортой хадгалах зарчим баримталдаг ажээ. Эндээс үзвэл орон зайн эзэмшлийн хувьд явагддаг тэмцэл нь эцсийн эцэст орон зайн хязгаарын төлөө байдаг гэсэн дүгнэлт, ойлголт гарч байна. Хязгаар гэдэг үгийг Монголчууд улсын хилийн шугамаар заагласан газар нутгийн хязгаар, мөн хязгаар нутгийн тодорхой зурвас бүс нутгийн хэмжээнд ойлгодог хоёрдмол утга хадгалдаг. Орос хэлний толь бичигт “хязгаар гэж ямарваа юмны эцсийн шугам, эцсийн хэсэг” [С.И. Ожегов. М., с.294] гэж тайлбар өгчээ. Монгол хэлний товч тайлбар тольд хязгаар гэсэн үгийг “... хилийн зааг ... улсын нутгийн хязгаар...” гэж илэрхийлжээ. [Я.Цэвэл. 1966. х. 770.]

Гуравдугаарт: Аль ч улсын эзлэх орон зайн хязгаар нь нөгөө улстай хамтран шийдвэрлэсэн улсын хилээр тогтоогдож баталгааждаг зүй тогтлыг монголчууд анх хөрштэйгээ хамтран бий болгож хүн төрөлхтний түүхийг баяжуулжээ.

Хүннүгийн үед Монголын умард хэсэгт аюул учруулахаар харь үндэстэн байгаагүйгээс гадна ус намаг шигүү тайгаар хүрээлэгдсэн учир учрах аюул энэ чиглэлд үндсэндээ байсангүй. Харин өмнөд чиглэлд томоохон гүрнээс, Иньшаний нурууг даван Монголд учруулах аюул тасраагүй байна. Монголчууд ч улсын эдийн засаг цэргийн тулгуур түшиц газар болох энэ уул нурууг харьд алдахгүйн төлөө хүчтэй тэмцэл явуулдаг байжээ. Хоёр талын эзэмшлийн орон зайн хязгаарыг энэ чиглэлд зааглаж эрх зүйн үндэстэй болгоход Хүннү Хан Улсын хооронд 2200 жилийн тэртээ байгуулсан найрамдлын гэрээ туйлын чухал үүрэг гүйцэтгэв.

Хүннүгийн үеийн хилийн баталгаажилт хамгаалалт нь Монголчууд төдийгүй, дэлхий дахины онцгой анхаарлыг татдаг. Зэрэглэн орших хоёр талын улсууд эрх ашгаа хамгаалахаар явуулсан байнгын тэмцлийн үр дүнд Хүннү, Хятадын хан улсын хооронд МЭӨ 198 онд хил албан ёсоор тогтоон тэмдэглэгдэн найрамдлын гэрээ байгуулагджээ. Уг гэрээнд Хятадын эзэн хааны хүлээн зөвшөөрснөөр түүний нэгэн айлталд “Хүннү, Хан улс эн зэрэгцэх улс мөн. Цагаан хэрэмнээс хойши нум сум агсагчдын улс нь Шаньюйн зарлигийг дагаж, цагаан хэрэмнээс урагши түшмэдийн бүс малгай өмсөгчдийн суудаг орон нь харин надад захирагдана” [Таскин.В.С. Материалы по истории Сунну. 1968. С. 47-48] гэжээ.

Эндээс дараах дүгнэлт сургамж гарч байна. Үүнд:

- Улсын эзэмшлийн орон зайг тухайн улс дангаар шийдвэрлэдэггүй, журам мэт нөгөө улсын төрийн эрх байгууллагаас хүлээн зөвшөөрсний үндсэн дээр хамтаар тодорхойлж тогтоосон нөхцөлд олон улсын шинж чанартай, эрх зүйн үндэс бүрэлдэн бий болдог зүй тогтол ажиглагдаж байна. Одоогийн мөрдөж байгаа Хилийн тухай хуулинд “Монгол Улсын нутаг дэвсгэрийн хязгаарыг газрын гадаргуу, усны мандал дээр хил залгаа улсын нутаг дэвсгэрийн хязгаараас зааглаж Монгол Улсын олон улсын гэрээгээр тодорхойлж, тогтоосон шугамыг Монгол Улсын хил гэнэ. Уг шугамнаас эгц дээш агаарын мөн шугамаас эгц доош газрын хэвлийн хил байна”: [Монгол Улсын Хилийн тухай хууль. 1993. х.2] гэж тодорхойлолт өгчээ. Хүннүгийн үед хил тогтоосон цагаас хойш энэ хууль гарсан оны хооронд 2191 жилийн зайтай хугацаа гарч байна.

- Улсын хилийг тогтоох, энэ талаар тогтоосон дэглэмийг сахихад хоёр этгээд тэгш бус биш, том жижгээр ялгагдалгүй адил тэгш байдал, итгэл үнэмшил, нөхөрсөг хамтын ажиллагаанд тулгуурладаг зарчимтай болохыг энэ гэрээгээр нээн харуулжээ. Одоо ч дэлхий дахинд улсын хилийг тодорхойлох, тогтоох, тэмдэглэх, хэрэгжилтыг хангах энэ зүй тогтлыг үндсэн зарчим болгон ашигласаар л байна. Хүннү Хан улсын хооронд хэдийгээр хүчний харьцаа Хан улсад ашигтай байсан ч, ерөнхий жингээр нэг нь нөгөөгөө хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй тэнцвэрт харьцаа үйлчилж байсныг энд зориуд тэмдэглэе.

Л.Н.Гумилев “Шинэ эриний босгон дээр Хятадын хүн ам 59,6 сая хүрч байхад Хүннү нь гурван зуун мянган орчим хүн амтай байлаа. Хан, Хүннү хоёрын хүчийг харьцуулахын аргагүй гэж

Хятадын удирдлага, зөвлөхүүд үзэж байв. Гэвч улс гүрнүүдийн хүчний харьцааг оршин суугчдын тооноос гадна гарвал үүслийн хөгжлийн үе шаттай холбон үздэг гэж тэмдэглээд ... Хятадын арми нь хил орчмын омгийнхон, мөн гэмт хэрэгтэн (залуу гайхал)-үүдээс бүрдэж байлаа. Хэдийгээр гайхамшигтай сайн жанжнуудтай байсан ч Хятадын армийнх нь байлдах чадвар өндөр байсангүй ... гэтэл Хүннүгийн “цэрэг”, “ард” нь ялгалгүй (нэгдмэл шинжтэй утгачлав. Ш.А) нэгдмэл байсан учраас МЭӨ 202-57 онд хэдийгээр Хүннү цөөн хүн амтай байсан ч Хятадын Ханийн түрэмгийллийг саатуулан” няцааж байсан [Гумилев.Л.Н. Хүннү в Азии и Европе. Журнал “Вопросы истории” № 6, 7, 1989.] гэж бичжээ.

Энэ тэнцвэрт харьцааг дараа дараагийн зуунуудад Монгол хадгалж чадаагүйн улмаас сөрөг талд ашигтайгаар эргэж, тэгш эрх үйлчлэх зарчмаасаа гажихад хүрчээ.

- Улсын хэмжээнд тэнцвэрт харьцааг бий болгоход цаг хугацаа боломж хэрэгтэй. Гэвч улсын хил дээр, хил орчимд тэнцвэрт харьцаа бүрдүүлэх боломжийг бид эрэх ёстой гэсэн сургамж бас гарч байна.

- Хил тогтооход улсын хилийн шугамыг бат бэх, ил тодоор тэмдэглэх, түүнийг нэвтрэх бололцоо нөхцөлийг хаасан саад байгууламж барих шаардлагатай зүй тогтол хилийн баталгаажилтанд үйлчилдгийг эндээс төвөггүй харж болох юм.

Улсын хил гэдэг юу юм бэ гэдгийг хоёр талын хэн ч гэсэн харж мэдэх боломж олгосон цагаан хэрмийг барьж байгуулсан нь хятадын ард түмнээс дэлхийн мартагдашгүй сан хөмрөгт оруулсан тодорхой хувь нэмэр билээ. Ийм хэрэм барьж байгуулахад хүргэсэн Монголчуудын өвөг дээдсийн гавъяа бас тэднээс дутахгүй гэж үзэхэд алдас болохгүй биз ээ. Цагаан хэрэм баригдсан гол зорилго нь хил хамгаалалтанд гарах хөрөнгө хүч хэмнэхээс гадна улсын хил давах, зөрчих санаа зорилготой этгээдүүдэд уналга ашиглан нэвтрэх бололцоог хаахад чиглэсэн байна гэсэн дүгнэлт хийхэд хүргэж байгаа юм. Явган хүнд бэрхшээлтэй боловч хэрмийг давж болох боломжтой нь маргаангүй. Харин тэр үеийн тээврийн зонхилох хэрэгсэл байсан мориор хэрмийг дуртай хэсгээр давж нэвтрэх ямар ч боломжгүй болсон байв. Энэ талаар улсын хил хамгаалахад тээврийн хэрэгсэл ашиглан нэвтрэхэд саад хаалт байх шаардлагатай гэсэн үнэт сургамж үлдээснийг одоо ч дэлхий нийтээр ашигласаар байна. Тэр саад хаалт нь шинжлэх ухаан,

техникийн дэвшлийн хөгжлийн түвшингээс шалтгаалан янз бүрийн хэлбэрээр ашиглагдаж иржээ. Монголд ердийн саад ашиглаж байхад, Орос, Хятадал дохиоллын систем ашиглаж байна. АНУ, Англи, Япон зэрэг улсад сансар газрын автомат системийг, нисдэг тэрэг онгоцонд байрлалтай шуурхай бүлэгтэй хослон хэрэглэх чиглэлээр хил хамгаалалтад ашиглаж байна.

- Улсын хилийн тодорхой хэсгээр гарц хаалга гарган хоёр талын эрх ашгийг харгалзан хилийн харилцааг өргөн дэлгэр хөгжүүлж ашиглаж иржээ. Улсын хилээр шалгаж нэвтрүүлэх албыг бий болгож үр бүтээлтэй ашиглаж байсан баримт их бөгөөд түүний анхдагч нь мөн л Хүннүд оногдож байна. Л.Н.Гумилев Хан улс Хүннү хоёрын хооронд “хэдийгээр соёлын хувьд хоёр улс гүн гүнзгий ялгаатай боловч хүнс тэжээлийн худалдааны солилцоог зохицуулахын хувьд хөгжлийн хангалттай өндөр түвшинд байсан юм” [Гумилев. Хунно-Китайская война III-II вв. до Н.Э] гэжээ.

Дөрөвдүгээрт: Улс оронд учирч болох аюулаас сэргэмжлэх чиглэлээр мартахын аргагүй сургамж гарч байна. Тэр нь өөрийн онцлогтой байв.

- Учрах аюулыг хугацааны хувьд байнгын ба түр зуурын гэж ангилж үзэх боломж бүхий сургамж гарч байна. XIII, XIV, XV зууныг эс тооцвол Монголын төрт ёс бий болсон цагаас хойшхи бараг 2000 шахам жилийн хугацаанд Монголд учрах гадаадын аюул байнгын шинжтэй давтагдан дагалдаж иржээ.

- Аюулд өртөж болох гол объект нь Монголын эзэнт төрийн тэргүүн, түүний төвлөрдөг нийслэл байжээ. Нийслэл нь Монгол Улсын төв хэсэгт, тэр тусмаа уул, ус, байгалийн өнгө, үзэмж, баялаг хосолсон Орхон, Туул голын сав хөндийд байрладаг учраас түүнд хамгийн ойр дөт газраас түргэн хугацаанд гарч очих боломжийг дайсан хайдаг байв. Үүнээс ач холбогдлоор дутахгүй объектонд Монголын соёл иргэншил тухайлбал хэл бичиг, түүх соёл, зан заншил, хүн амын удмын сан орж байжээ гэсэн дүгнэлт хийж болох юм. Энэ чиглэлээр хилийн орон зайд анхаарах сургамж их байна.

- Түрэмгийллийн зорилго нь өөрийн эзэмшлийн орон зайг тэлэх, Монгол гэдэг улсыг ертөнцийн улсуудын эзэлдэг орон зайнаас хасаж, түүний эзэлж байсан орон зайг өөрийн эзэмшлийн орон зайн хүрээнд оруулж багтаан авах уусгахад чиглэж байжээ.

Зорилгодоо хүрэхийн тулд Монгол Улсын эзлэх орон зайнаас чимх, чимхээр, ямх, ямхаар өөрийн хавсарга болгосоор эцсийн зорилгоо хангахад чиглэж байсан нь ажиглагддаг. Хил орчмын газар нутаг түүний баялгийг бид маш нарийн судалж мэдсэн байх хэрэгтэй болов.

- Түрэмгийлэл явуулах аргад томоохон зэвсэглэсэн хүчнээр гэнэдүүлэн цохиж устгах, дотроос нь хагалан бутаргаж удирдлагыг нь алдагдуулах, энэ хоёрыг хорших үндсэндээ гурван аргыг зонхилон хэрэглэжээ. Цэргийн хүчээр цохиж устгах арга нь тэр бүр амжилтанд хүрч үр дүнгээ өгч байсангүй. Энэ нь монголын морин цэргийн маневрлаг шинж, цэргийн урлагтай холбогдож байлаа. Дотроос нь хагалан бутаргах арга нь Монголын байлдах чадварыг сулруулж байсан ч дайсантай хавсран Монгол үндэстний сөрөг талаа устгах оролдлого Монголчуудын хувьд харьцангуй бага байснаас гадны түрэмгийлэлд тэр бүр үр дүнтэй ашиг өгч байсангүй. Харин удирдлага буюу төрийн өндөрлөгийн төлөө хагарал тэмцэл өрнөсөн үеийг далим болгон гаднаас гэнэдүүлэн цэргийн хүчээр цохих арга нь хөнөөл ихтэй, Монголын нийгэм төр суларч, харийн дарангуйлалд орж түүний ноёрхолд урт хугацаанд байх уршигт хүргэж байв.
- Гадаадын аюул бодит шинж агуулгатай байлаа. Аюулыг өөр дээрээ бий болгохыг Монголчууд үүсгээгүй, хүсээгүй. Харин энд хүчтэйгийн өмнө хүчгүй нь буруутай гэсэн шударга бус зарчим үйлчилжээ. Ийм байдал хүчний чанарын түвшин ерөнхийдээ ойролцоо байсан үед ч ажиглагдаж байсныг Л.Н.Гумилев тэмдэглэж байв. Хүннү Хан гүрний хооронд явагдсан дайны бодлого үйл ажиллагаанд шинжилгээ хийгээд ийм дүгнэлтэнд хүрсэн байна. Тэрээр “Хүннүчүүд зэрлэгүүд биш харин ард түмэн, тэдний эрх ашгаас тасарсан Ханийн дарангуйллын дээд удирдлагын ажиллагаа нь цус урсгасан дайныг өөгшүүлэн дэвэргэж байсан нь Хүннүгийн ард түмний бут ниргэлт, Ханийн дарангуйлал унаснаар төгсгөл болсон юм” [Гумилев Л.Н. Хүнно-Китайская война III-II вв. до Н.Э.] гэжээ. Монголчууд нөмөрсөн аюулын өмнө сөгдөж байгаагүй, тэр аюулыг арилгахын төлөө тэмцэж байсан онцлогтой. Харин нөмөрсөн аюулыг арилгаж түрэмгийллийг Монголчууд няцааж, устгаж байсанаар зарим үед хоёр гурван зуун жил хэвийн

хэмжээнд аюул багатай орчинд оршин амьдарч байв. Гэвч аюулын үндэс бүрэн арилаагүй, арилгах боломж ч байгаагүй учир дахин давтан сэргээгдэж байсан нь гадны аюул нь бодитой байнгын шинжтэй байсныг харуулж байгаа юм. Эндээс үүдэн Монголын хил хамгаалах цэрэг нь ямар ч үед алба-байлдааны бэлэн байдлыг өндөр түвшинд байлгах шаардлага гарч байна.

Тавдугаарт: Эх орноо хамгаалах, хөгжүүлэхийн төлөө явуулсан гайхамшигт тэмцлийн үр дүнгээс авах сургамж асар баялаг юм. Тэр нь ерөнхийдөө улсаараа, нийгмээрээ, ард түмэн бүгдээрээ өөрийн эзэмшлийн уугуул газар нутагт айх аюулгүй амар түвшин аж төрөх уламжлал хадгалсан үндэсний амин чухал ашиг сонирхол байжээ. Энэ бүхэн цул нэгдэлтэй, харилцан уялдаатай төрийн бодлого ард түмний нэгдсэн үйл ажиллагаа байсан юм. Энэ бүгдийг хооронд нь ангилан ялгах салгахад төвөгтэй, тэгэх ч шаардлагагүй. Яагаад гэвэл тэр ард түмний хооронд, иргэд цэргийн хооронд, улсын хөгжил, батлан хамгаалалтын хооронд зааг ялгаа бараг байхгүй, хамтаар аж төрж, хамтаар эх орноо хамгаалахад босдог нэгдмэл хуулинд захирагддаг онцлогтой байв. Үүнийг судлан шинжлэх үүднээс нэгдсэн нэгэн орон зайд нь багтааж үзэж болох юм. Тэр үеийн эх орон гэсэн нэгэн ойлголт буюу газар нутаг, төр, нийгмийн байгуулал, иргэдийг багтаасан энэхүү орон зай нь гадны аюулын нөлөөнөөс шалтгаалан хумигдаж багасах, эргэж тэлэгдэж анхны орон зайн хязгаарт орох, эсвэл хамгийн бага хэмжээнд орж тогтворжих ийм гурван орон зайгаар л ялгардаг. Харин Монголын хувьд дэлхийд, Азид эзлэх энэхүү орон зай, тухайлбал Манж шиг устаж, уусч үгүй болоогүй энэ хир явж ирсэн онцлогтой.

Эх орноо хамгаалах зорилго, эрх ашигт нийцүүлэн явуулсан дайн, тулалдаан, байлдааныг судлан үзэхэд дараах хууль, зүй тогтлын шинжтэй сургамж гарч байна. Үүнд:

- Нөмөрч болзошгүй аюул нь эсрэг талаас өөрийгөө ялангуяа хил хязгаараа хамгаалах зайлшгүй байдалд хүргэдэг зүй тогтол үйлчилдэг байна. Монголд учрах гадны аюул байнгын шинжтэй үйлдэл байсан учраас улс орноо нэгдэн хамгаалах цэрэг иргэний хосолсон тогтолцоог Монгол Улс урт хугацаанд хадгалахад хүргэжээ. Одоо ч гэсэн Хилийн цэрэг, хил орчим байгаа иргэд байгууллагын

анхаарлыг иж бүрнээр улсын хилийн халдашгүй дархан байдал зангидаж нэгтгэх механизм бүрдүүлэх хэрэгтэй болов.

- Хүчний харьцаанаас аюулын идэвхжил, хамгаалалтын чанар шалтгаалдаг зүй тогтолт үзэгдэл гарч байна. Гадны аюул байсан хэмжээгээр түрэмгийлэл үйлдэгдэж байгаагүй. Ойролцоогоор нэг зуун, ихэнх төлөв 2-3 зууны хооронд дайны аюул идэвхжсээр түрэмгийлэл үйлдэгдэх нөхцөл бүрдэж байжээ. Аюулын идэвхжлийг сулруулах зорилгоор түрэмгийллийг няцаахад хүчний тэнцвэрт харьцаа дутагдсан нөхцөлд гадны боломжтой гэж үзсэн хүчийг хамсаатны хэмжээнд ашиглаж байв. Түрэг, Уйгар, Киргизийн довтолгооны үед нэгнийх нь эсрэг нөгөө хүчийг ашигласан байж болох магадлал харагддаг. Чингисийн үед энэ аргыг өргөн ашигласан. Хаант Оросын зүгээс үйлдсэн газар нутгийн түрэмгийллийг зогсоохын тулд Манжийн тусламжийг авсан зэрэг үйл ажиллагааг үүнтэй холбож болох юм.

- Үндэсний хэл бичиг, түүх, соёл, зан заншлаа өргөн дээдэлсэн үзэл бодол нь аливаа улс оршин тогтнохын тулгуур үндэс болдог зүй тогтол тодорхой хэлбэрээр гарч иржээ. 22 зууны турш Монголчуудын эрхэмлэсэн хамгийн дээд үзэл бодол түүний үр дүн бол энэ юм.

- Эдийн засгийн хүчин чадал, батлан хамгаалах боломж хоёр цул нэгдэлтэй байж аюул учруулагч этгээдийн тухайн цэрэг-эдийн засгийн түвшингээс доогуургүй буюу ойролцоо байх чанарыг хадгалах зүй тогтол байгааг олж үзэж болох юм.

Л.Н.Гумилевын тодорхойлсон “цэрэг”, “ардын” нэгдмэл байдал дээр эдийн засгийн чадавхийг нэмбэл энэ зүй тогтол их тодорхой ойлгогдоно. Монголчууд өөрийн эзэмшлийн орон зайн заагийг хадгалах, алдвал тэр хэмжээнд сэргээх, одоогийн байгаагаас дотогшуулалгүй хадгалсан тэмцлийн гол үр дүнгийн хамгийн чухал нь энэ юм.

- Улс орны дээд удирдлагын чанар чансаанаас улс орны хувь заяа шалтгаалдаг зүй тогтлыг Монголчууд онцгойлон үзэж мөрдөж байжээ. Цэрэг иргэний нэгдмэл тогтолцоо чухал үүрэг гүйцэтгэснийг дээр нэгэнт тэмдэглэсэн. Ийм тогтолцоо Монгол орны хувьд үеэ өнгөрөөсөн гэж үздэг хүмүүсийн үзэл бодолтой тэр бүр санал нийлэхгүй байна. Цэрэг иргэний нэгдмэл тогтолцоо жинхэнэ байсан хэв шинжээсээ манай эриний XIII зууны сүүлийн

хагасаас үгүй болох эх сууриа тавьсанаас хойш долоон зууныг өнгөрч байна гэж үзэхэд буруудахгүй. Монгол бол АНУ, Япон, Орос, Хятад, Англи, Герман мэт хүн ам арвинтай, өөрийгээ авч явах эрийн цээнд хүрсэн хэнээс ч хэзээ ч айх аюулгүй болсон гүрэн бишээ. Том гүрнүүдийн удирлагын бүх субъектүүдийг энгийн, тэгсэн мөртлөө цэргийн алба хаасан, цэргийн эрдэмд сурсан иргэд л удирдаж байна. Хятад мэт их гүрэн цэрэг иргэний нэгдсэн тогтолцоог халгалж байна. Би ардчиллыг үзэн ядсандаа биш, бүгдийг цэргийн албан тушаалтан удирдах байр сууринаас биш, бүх ард түмнээ цэрэг болгох байр сууринаас биш, зөвхөн энгийн иргэд төрийн удирдлагын бүх субъектэнд томилогдон ажиллахад иргэний нэгэн адил цэргийн эрдэм боловсрол, эзэмшсэн байх ёстой гэж үзсэнээс энд бичиж байна. Энэ бол монголын өөрий нь өвөрмөц онцлог юм. Энэ бол том ухаан их урлаг гэдгийг эзэн Чингис гаргаж тавьсан юм. Тэр зөвхөн өөрийнхөөсөө бус өөрий нь шархдуулж амийг нь хорооход хүргэсэн дайсныхаа эрдэм ухаан чадлыг бишрэн өөрийн өрлөг жанжин, хамгийн дотны нөхрөө болгож, тэр нь Монгол Улсын төлөө гайхамшигтай гавъяа байгуулсныг яагаад бид мартаж үл тоомсорлох ёстой юм. Монголын өвөг дээдсүүдийн хөлс цусаар бий болгосон цэрэг-иргэний тогтолцоо бол дэлхийн яндашгүй хувиршгүй, үнэлэхийн аргагүй баялаг. Дэлхий даяар үүнээс сурч, үр дүнд хүрч байхад Монголчууд яагаад үл тоомсорлож, элэг доог болгож хаях ёстой билээ гэсэн харамсал яах аргагүй төрдөг.

Удирдлагатай зайлшгүй холбон үзэх ёстой нэг асуудал бол хэдэн мянган жилийн тэртээ Монголчуудтай ойролцоо буюу түүнээс ч дор түвшинд байсан хөрш гүрнүүд үйлдвэр хөдөө аж ахуйн орон болоод дэлхийд нөлөөлөх гүрнүүд болсон байхад Монгол Улс хоцрогдсон орны тоонд үлдэн хоцрох болсныг судалж сургаж авах явдал юм. Энэ талаар эрдэмтэн судлаачид үгээ хэлнэ бизээ.

Үүнийг юуны урьд гадны аюулын нөлөө түрэмгийллийн уршиг үр дагавартай холбон үзэхээс өөр аргагүй. Тэд Монгол Улсыг хөгжих бололцоо олголгүйгээр хүн төрөлхтний хөгжлийн гадна үлдээжээ. Түүгээр ч үл барам эзэн Чингисийн үед бий болгосон Монголын нийслэл Хар хорум мэт, бусад суурин түүх дурсгалын газруудыг дайсан уулгалан устгаж газрын хөрстэй тэгшилжээ. Түрэг, Уйгар, Киргиз, Манж, Хятад зэрэг гадаадын түрэмгийлэгчдээс

гадна Хубилай хаан зэрэг Монголын хаад ноёдын үйл ажиллагаа бас нөлөөлжээ. Ялангуяа дэлхийд техникжилт үүсч бий болж эхэлсэн тэр үед Манжийн дарангуйлалд өнгөрөөсөн 200 гаруй жилийн хугацаанд хөрш улсуудын хөгжил эрчимтэй явагджээ. Монгол Улсыг хэвийн хэмжээнд умар, өмнөд хөршөөс хоцрохгүй байх түвшинд хүртэл хөгжүүлэх нь тус улсын тусгаар тогтнол, бүрэн эрх, газар нутгийн бүрэн бүтэн байдал, хилийн халдашгүй дархан байдалтай салшгүй холбоотой. Энэ нь улс орны хөгжил, батлан хамгаалалтанд онцгой анхаарч бүтээлч шийдэмгий хандах хариуцлагыг иргэн, улс, нийгмээс шаардаж байгаа юм.

Зургаадугаарт: Улс орноо хөгжүүлэх, хамгаалах нь нэгэн цул нэгдэлтэй байсан боловч дотроо бидний одоогийн нэрлэдгээр стратеги, оперативын урлаг, тактик өөрөөр хэлбэл дайтах, тулалдах, байлдах тодорхой аргуудтай байжээ.

- Гадны аливаа халдлага түрэмгийллийг няцаах устгахын тулд улс орон хэзээд ч бэлэн байх тогтолцоог улсын хэмжээний бодлого, үйл ажиллагаа болгосон байна. Тэр нь цэрэг иргэний жинхэнэ бодит тогтолцоо байлаа. Дайн тулалдаанд хүүхэд өвгөд, хөгшид, эмэгтэй, эрэгтэй бүгд ялгалгүй эх орноо аюулаас хамгаалах улс төр, ёс суртахууны тодорхой үүрэг, хариуцлага хүлээдэг байв. Албан ёсоор цэрэгжин эх орноо хамгаалах эр насыг 18-60 насаар хязгаарласан байна. Үнэн чанартаа ухамсарт амьдралын бүх насыг эх орондоо зориулсан тогтолцоо байв. Цэргийн байгуулалтын тогтолцоо нь “гэр, цэрэг”, аравт, зуут, мянгат, түмтийн хэлбэртэй байв. Улс орны батлан хамгаалах цэргийн тогтолцоо нь хязгаарын мянгатын цэрэг (хил хязгаарын аймаг), дотоодын мянгат (гүний аймгууд) торгон цэрэг (төв засаглалыг хамгаалах байнгын шинжтэй) гэсэн үндсэндээ гурван хэсэгт хуваагдан тэдний дийлэнх нь хязгаартаа, бусдыг аюул тохиолдсон нөхцөлд бэлтгэл хүчний хэлбэрээр ашиглах чиглэл баримталжээ. Тэгэхдээ улсын хэмжээгээр аюул тохиолдох магадлал өндөртэй 3-4 чиглэлд байлдаанд байнга бэлэн байх зориулалтаар цэргийн хүчийг стратегийн түвшинд бүлэглэн байрлуулдаг байжээ. Энэ нь тухайн чиглэлийн учирч болзошгүй түрэмгийллээс сэргийлэх, няцаахаас гадна шаардлагатай үед аль нэгэн хэсгээс нөгөө чиглэлд хүчийг шилжүүлэн бүлэглэх давхар зориулалттай байжээ гэдгийг удаа дараагийн дайны туршлага харуулж байна.

Монголчуудаас өөрийн эзэмшил уугуул нутгийн хязгаарыг эрх зүйн хэмжээнд хадгалах, сэргээх хамгаалах зориулалтаар явуулсан бүх дайн тулаан, байлдаан зайлшгүй явагдах, зэвсэгт тэмцлийн бодит хуулинд захирагддаг байсан учраас шударга шинж чанартай байлаа.

- Монголчуудын батлан хамгаалалтын тогтолцооны үндсэн зарчим нь орон нутгийн буюу хязгаарын мянгатуудын нэгдсэн бодлого хүчээр явуулах тулалдааны бэлтгэл, үйл ажиллагаа байв. Монгол Улсын хязгаарын газар нутаг, нийгмийн байдал, иргэд нь өвөрмөц хэсгээр зааглагдан хуваагдсан тодорхой мянгатуудын харъяалалд байж, тухайн чиглэлийн аюулгүй байдлыг хангах үүрэг хариуцлага хүлээсэн тогтолцоо нь нэгдүгээрт газар орон, гадны аюулыг эртнээс байнга тандан судалж байдлыг нарийн мэдэж хараа хяналтанд байлгадаг. Хоёрдугаарт тухайн аймгийн иргэд тэр л чиглэлд амьдарч, алба хаах учраас газар нутаг, хүн амын суурьшил, зан заншлын тухай өргөн мэдлэг, дадлага чадвар эзэмшсэн байдаг, гуравдугаарт аравт, зуут, мянгатын удирдлага нь тухайн төрийн захиргааны бүтэц, зохион байгуулалтыг эрхлэн удирддаг учраас нэгдмэл удирдлага, нэгтгэн захирах зарчмыг бүтээлчээр хэрэгжүүлэх боломж хадгалжээ. Шаардлагатай үед нэмэгдэл хүчийг тухайн хэсэгт өөр аймгаас зохицуулж өгдөг учраас гүнийн давхар хамгаалалтын тогтолцоонд байсан нь найдвартай байдлыг хангаж байлаа.

- Хилийн дагуу байгаа аравт, зуут нь оршин суугаа газар нутгийн хэмжээгээр тухайн чиглэлийн хилийн хэсэг, гүнийг давхар хариуцдаг байв. Оршин суугаа газраараа өтгөс, нялхас, эр эм ялгалгүй сонор сэрэмжтэй байж сэжигтэй этгээдийг илрүүлэх, саатуулах, мэдээлэх эрх үүрэг хариуцлага хүлээдэг байв. Хилийн зөрчил, будлиан гарсан үед хамтын хүчээр эрэл хайгуул явуулж, илрүүлэх баривчлах, устгах үүрэгтэй байжээ. Иргэд Монгол Улсын хилийн ойр оршин сууж хилийн аюулгүй байдлыг хангах хэрэгт оролцдог онцлогыг нь харгалзан элдэв татвар төлөөсөөс чөлөөлж урамшлын нэмэгдэл арга хэмжээ авч байжээ. Үүний хамт төрийн хамгаалалтын чанарыг хадгалах, хил зөрчигчдийг мэргэжлийн бэлтгэгдсэн хүчээр амжилттай шийдвэрлэхийн тулд тусгай зэвсэг бүхий мэргэжлийн харуулчдыг хилийн харуул манааны хэлбэрээр ашиглаж байжээ. Тэдний бүрэлдэхүүн төсөв хөрөнгийг гол төлөв

оршин суугаа, аравт, зуут, мянгатаас хариуцан гүйцэтгэх тогтолцоогоор зохицуулагдаж ирсэн нь сургамжтай юм. Улс орны цэрэг иргэний нэгдсэн ийнхүү тогтолцоо нь дайсан этгээд ганц нэгээр буюу бүлгээр улсын хил хязгаар нэвтрэх, хаагуур ч явсан илрэхгүй, саатуулагдахгүй өнгөрөх боломжгүй учраас одоо ч ач холбогдлоо алдаагүй байна.

Дотоодоос улсын хил зөрчсөн этгээдийг цаазлах, торгох өөр газар шилжүүлэх цөлөх ар гэр, ах дүүд нь хүртэл ял зэмлэл оногдуулдаг учир иргэдээс хилийн дэглэм журам сахих хариуцлага өндөр, бас иргэдийн харилцан хамааралтай хяналт шалгалт жинхэнэ ёсоор орших нөхцөл бүрдэж байжээ.

Мөн цэргийн бүх үйлдэл иргэний, тэр тусмаа орон нутгийн хяналтанд байсан учраас албыг чамбай гүйцэтгэх, хариуцлага сахилга алдахгүй байх орчин бүрдэхэд таатай нөлөөлж байжээ.

## ЗҮҮЛТ

1. Далай.Ч. Түүвэр зохиол. I УБ., 2000. х. 195
2. БНМАУ-ын түүх. I боть. УБ., 1966. х. 83
3. Таскин.В.С. Материалы по истории Сюнну. М., 1968. С. 47-48.
4. Монгол цэргийн түүхэн товчоон. Тэргүүн дэвтэр. 1992. УБ., х.20
5. Доржсүрэн.Ц. Умард Хүннү. УБ., 1981. х. 56
6. Руденко. С.И. Культура Хүннов и Ноинулинские курганы. М., 1962. с. 65
7. Гумилев. Л.Н. Хүннү в Азии и Европе. Журнал "Вопросы истории. № 6,7. 1989.
8. Бичурин.Н.Я. Собрание сведений о народах обитавших в средней Азии в древние времена. т.II, III. М-П., 1950. с 157.
9. Сүхбаатар. Г. Монголын түүхийн дээж бичиг. Тэргүүн дэвтэр. УБ. 1992. х. 31
10. Сүхбаатар. Г. Нирун Улс. УБ., 1992. х. 111
11. БНМАУ-ын түүх. Нэгэн боть. УБ., 1984. х. 125
12. Грумм-гржимайло. Г.Е. Западная Монголия и урианхайский край. т. II, I., 1926., с.331-332.
13. Сүхбаатар.Г. Монголчуудын эртний өвөг. УБ., 1980. х. 92
14. Яковлева. П.Т. Первый Русско-Китайский договор в 1689 г. М., 1958. с. 76
15. Насанбалжир.Ц. Ар Монголоос Манж чин улсад нийлүүлж байсан алба. УБ., 1964. х. 123
16. Батбаяр.Ц. Монгол ба Япон XX зууны эхэн хагаст. 1998. х. 188
17. Гумилев. Хүнно-Китайская война III-II в.в. до Н.Э. Интернет. "Гумилевка". <http://kulichi.ramb.ru> [~Gumilev]
18. С.И.Ожегов. Словарь русского языка. М., с. 294
19. Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ. 1966. х. 770
20. Монгол Улсын Хилийн тухай хууль. УБ., 1993. х. 2